

ХУБИЛАЙ ХААНЫ ЖУУ БИЧГИЙН МОНГОЛ ОРЧУУЛГЫГ ДООР СИЙРҮҮЛБЭЛ:

"Дээр Тэнгэрийн Ивээл-
дор

Их Монголын Улсын Хуанди, Япон улсын ванд Бичиг илгээж амуй.

Мөхөс миний бодоход, Бага улсын хаад хил савлахын цагт харилцах зам хайж, зетэн найрамтах арга сүвэгчилдэг нь эртний уламжлал.

Өвөг дээдэс ману, Тэнгэрийн ивээлээр таван өнгө улсыг мэдэлдээ оруулж, холхи алсад ч бидний их хүчээс эмээж, эрдэм нигүүлслийг минь бишрэгч орон тоолж баршгүй олон. Мөхөс би бээр сууринаа суусан эхэн цагаас, дайн самууны хөлд он удаан шаналж асан Гуулин/Солон-

гос/ улсын энгийн номхон иргэдийн зовлон зүдгүүрийг нимгэлж, цэргээ татаж, нутаг орныг нь зүүлэн өгч, хөгшин залуугүй буцаасанд Гуулин ван, түшмэл түшээд талархан, Гүрэнд айлчилсан бөлгөө.

Тийнхүү мөхөс миний улс ба Гуулин улс нь Их Төрөөр бол, хаан ба албатын харилцаатай боловч чухам санаа нь эцэг хөвгүүдээс юу ялгарах аж. (Японы) ван ба албат иргэд ч үүнийг аль хэдийний мэдэж буй буй заа. Гуулин улс миний дорно хөрш. Японтой нэн ойр. Япон нь, улс нээснээсээ янагш, Дундад улстай үе үе арилжаа наймаа хийдэг байсан атлаа, намайг сууринд сүүснаас хойш нэг ч удаа элч



зарж ирүүлэн зетэн найрамтатая хэмээсэнгүй. Вант улс (Япон) хараахан учир мэдэхгүй байгаа бололтой тул, тусгайлан элчид Бичиг өвөрлүүлэн илгээж, миний санааг

сайтар сэнхрэн ухтугай хэмээв. Өдгөөгөөс эхлэн, харилцан ирж очиж, амар мэндээ эрэлцэн, сайнаар зетэн найрамтгаас зохис.

Богд хүмүүн Дөрвөн далайг нэгэн хотол гэрт нэгтгээ хэмээх бөгөөд, харилцан ирж очиж, сайнаар эс зетэн найрамтах аваас, юуных нь нэгэн гэр бүлийн Зүй орших билээ. Эетэх, цэрэглэхийн алийг сонгохоо Ван сайтар тунгаатугай.

Тийн мэдтүгэй.

Жи-Юаны гуравдугаар он. Найман сар, өдөр" хэмээсэн байна.

ДОКТОР
С.ИДШИННОРОВ